



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2017 оны 04 сарын 27 өдөр

Дугаар 34

Улаанбаатар хот

**“Иргэдийн оролцоотой хяналттай орчин”  
хөтөлбөр батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь хэсэг, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7.6.1 дэх хэсэг, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 15 дугаар тогтоолын 4.3 дахь заалтыг тус тус үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Нийгмийн дэг журмыг хангах, хүн амыг эрүүл аюулгүй орчинд амар тайван амьдрах нөхцөлийг бүрдүүлсэн цогц бодлогыг хэрэгжүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд бүх нийтийн оролцоог бий болгох, хамтран ажиллах замаар гэмт хэрэг зөрчилгүй, хяналттай, амар тайван орчныг бүрдүүлж, хэрэг зөрчилгүй дүүрэг болгох зорилго бүхий “Иргэдийн оролцоотой хяналттай орчин” хөтөлбөрийг хавсралт ёсоор баталсугай.

2. Хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хэрэгжилт үр дүнг хагас, бүтэн жилээр дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд тайлагнаж ажиллахыг дүүргийн Засаг дарга /Ж.Эрдэнэбат/, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга /Ц.Алтанцацрал/ нарт үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга /Ц.Алтанцацрал/-д даалгасугай.

ДАРГА

Д.БАТ-ЭРДЭНЭ



1150100089

D:\2017\ Togtool

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн  
Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 04 дүгээр сарын  
27-ны өдрийн 34 дугаар тогтоолын хавсралт



**“ИРГЭДИЙН ОРОЛЦООТОЙ ХЯНАЛТТАЙ ОРЧИН”  
ДҮҮРГИЙН ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ  
ХӨТӨЛБӨР 2017-2020 ОН**

**Нэг. Өнөөгийн байдал, үндэслэл**

Улс орны нийгэм, эдийн засгийн янз бүрийн нөхцөл байдлаас шалтгаалан гэмт хэргийн шинж чанар өөрчлөгдөж байгаатай холбогдуулан гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг боловсронгуй болгох явдал чухлаар тавигдаж байна.

Дүүргийн хэмжээнд 2016 онд үйлдэгдсэн гэмт хэргийн гаралтын тоон үзүүлэлтийг товчлон хүргэвэл: Нийслэлийн Цагдаагийн газрын мэдээгээр Нийслэл Улаанбаатар хотод 2016 оны жилийн эцсийн байдлаар 17909 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 83 хэрэг буюу 3,7 хувиар өссөн бөгөөд Чингэлтэй дүүрэгт 2016 оны байдлаар 2950 гэмт хэрэг бүртгэгдсэн нь Улаанбаатар хотын нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 13,2 хувийг эзэлсэн байна.

2016 онд Нийслэлийн хэмжээнд бүртгэгдсэн онц хүнд гэмт хэргийн 3,5 хувь, хүнд гэмт хэргийн 1,8 хувь, хүндэвтэр гэмт хэргийн 2,5 хувь, хөнгөн гэмт хэргийн 3,9 хувь нь Чингэлтэй дүүрэгт бүртгэгджээ. Энэ нь өмнөх оны мөн үеэс 21,9 хувиар онц хүнд гэмт хэрэг буурсан, 24,6 хувиар хүнд гэмт хэрэг буурсан, 6,6 хувиар хүндэвтэр гэмт хэрэг өссөн, хөнгөн гэмт хэрэг 8,7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Судалгаанаас харахад гэмт хэргийн тоо өсөх чиг хандлагатай байгаа тул бууруулахын тулд архидалт, ажилгүйдлийг багасгаж, иргэдийн амжиргааны түвшинг дээшлүүлэх, хяналттай орчин бий болгох арга хэмжээ авах хэрэгтэй байгаа юм.

Иймд гэмт хэрэгтэй тэмцэх ажилд ахиц гаргахын тулд юуны өмнө бүх төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг тодорхой чиглэл, зорилготой, тусгай төлөвлөгөөний үндсэн дээр зохион байгуулж, дүүргийн хэмжээнд энэхүү хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага урган гарч байна.

**Хоёр. Хөтөлбөрийн зорилго**

Нийгмийн дэг журмыг хангах, дүүргийн хүн амыг эрүүл аюулгүй орчинд амар тайван амьдрах нөхцөлийг бүрдүүлсэн цогц бодлогыг хэрэгжүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд бүх нийтийн оролцоог бий болгох, татан оролцуулах, үүрэгжүүлж, хариуцлагажуулах, урамшуулах, хамтран ажиллах замаар гэмт хэрэг

зөрчилгүй, хяналттай, амар тайван орчныг бүрдүүлж, хэрэг зөрчилгүй дүүрэг болгоход оршино.

## **Гурав. Хөтөлбөрийн зорилт**

### **1. Хөтөлбөр хэрэгжүүлэх шаардлага**

Монгол Улсын Төрөөс баримтлах бодлогын баримт бичиг, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт Төрийн албыг чадавхжуулах, бүх шатанд мэргэшсэн албан хаагчидтай байж, Төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай, чирэгдэлгүй бөгөөд ил тод, нээлттэй үзүүлэх, нийгмийн итгэлцлийг бэхжүүлэн, Улс үндэстний аюулгүй байдлыг баталгаажуулахад чиглэсэн тодорхой зорилтуудыг дэвшүүлж, Төрийн байгууллага бүр өөрийн байгууллагаас үзүүлж буй үйлчилгээний чанартаа анхаарч, Төрийн үйлчилгээг хүнд сурталгүй, хүндрэл чирэгдэлгүй хүргэх, үйлчилгээндээ ухаалаг, шинэлэг, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх оролдлогуудыг хийсээр байна.

Манай Улсын Төрийн үйлчилгээ ард иргэддээ ойр бус, хүнд суртал ихтэй, нэг зөвшөөрөл авахын тулд олон байгууллагаар орж, гарын үсэг зуруулан, тамга тэмдэг даруулах шаардлагатай зэрэг хүндрэл бэрхшээл ихтэйгээс иргэд ихээхэн цаг алдаж, асуудлаа шийдвэрлүүлэхийн тулд олон хүний “гарыг цайлгах” хэрэгтэй болдог нь тэдний дунд ихээхэн бухимдал үүсгэхийн зэрэгцээ Улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд ч сөрөг нөлөө үзүүлдэг. Иймээс төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай, ил тод, ард түмэнд хүртээмжтэй болгох шаардлага бодит амьдралаас урган гарч байна. Энэ шаардлагыг хангаж, өнөөгийн байдлаас гарах нэг гарц нь “нэг цэгийн үйлчилгээ”, цахим засаглалыг хөгжүүлэх, Төрийн үйлчилгээ түүний чанар хүртээмжид иргэд хөндлөнгийн хяналт тавих, үйл ажиллагаанд нь үнэлэлт дүгнэлт өгөх тогтолцоог бий болгох, ингэснээр Төр нь иргэдийнхээ хэрэгцээ шаардлагад нийцсэн, үр ашигтай, хүртээмжтэй Төрийн үйлчилгээг нэвтрүүлэх явдал юм.

Авлигатай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэхэд Төрийн үйлчилгээг хүндрэл чирэгдэлгүй, хөнгөн шуурхай үзүүлэх, мэдээ мэдээлэл, үйл ажиллагаа, төсөв санхүүгийн ил тод байдлыг хангах явдал Төрийн байгууллагын үүрэг, оролцоо чухлаар тавигдаж байна.

Иймээс Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж, чанар хүртээмжийг нь сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, Төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх, төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах бодлогыг хэрэгжүүлэх шаардлага гарч байгаа юм.

### **1.2. Зорилт**

Авлигын хор хөнөөлийг иргэд, олон нийтэд тайлбарлан таниулах, авлигын эсрэг нийгмийн сэтгэл зүйг бий болгох, иргэний нийгэм, хувийн хэвшил, иргэдийн

идэвхтэй оролцоо, тэдний дэмжлэг туслалцаанд тулгуурлан авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлнэ.

### **1.3. Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

1/ Авлигатай тэмцэхэд олон нийтийг идэвхтэй оролцуулах, тэдний санал бодлыг хүргэх, авлигын нөхцөл байдал, авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих олон нийтийн хяналтын дэд зөвлөлийг дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн дэргэд байгуулан ажиллуулах;

2/ Хэвлэл, мэдээлэл, Төрийн бус байгууллага иргэдийн идэвхтэй оролцоо, дэмжлэгтэйгээр иргэдэд авлигын хор уршгийн талаар цэгцтэй мэдээлэл өгч, энэ чиглэлийн соён гэгээрүүлэх сургалт, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх;

3/ Дүүргийн Төр, захиргааны байгууллагын үйл ажиллагаа, төсөв санхүү, мэдээллийн ил тод байдлыг хангуулах, үйлчилгээндээ техник, технологийн шинэлэг арга хэрэгсэл, цахим үйлчилгээг нэвтрүүлэх замаар Төрийн үйлчилгээний хүндрэл чирэгдлийг багасгах арга хэмжээ авах;

### **1.4. Хүрэх үр дүн**

Авилгатай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажилд бүх нийтийг татан оролцуулах замаар авлигыг үл тэвчих нийгмийн уур амьсгал бий болгож, Төрийн байгууллагын үйл ажиллагааг нээлттэй ил тод болгосноор Төрийн үйлчилгээний хүнд суртал, хүндрэл чирэгдлийг багасган, иргэдийн Төрд итгэх итгэлцэлийг бэхжүүлнэ.

## **2. Хөтөлбөр хэрэгжүүлэх шаардлага**

Сүүлийн жилүүдэд хулгайн гэмт хэрэг эрс өсч Улс орны нийгэм, эдийн засгийн аюулгүй байдал, иргэдийн амьдрал, аж ахуйн нэгж, байгууллагын хэвийн үйл ажиллагаанд бодит бэрхшээл учруулж байна. Тухайлбал, 2016 онд улсын хэмжээнд гарсан нийт гэмт хэргийн 48,4 хувийг хулгайн гэмт хэрэг эзэлж Улс, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад 22,4 тэрбум төгрөгийн хохирол учруулжээ.

Хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх талаар төр, засгаас зохих арга хэмжээ авч байгаа боловч энэ төрлийн гэмт хэргийн тоо улам өсч, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд учруулсан хохирлын хэмжээ нэмэгдэж байгаа нь дараах бодит шалтгаантай байна. Үүнд:

- Иргэдийн цалгар назгай байдал болон аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагын ажлын зохион байгуулалт сул, харуул манааны сонор сэрэмж хангалтгүй, дэг журамгүй байдал /энэ байдалтай хулгайн гэмт хэргийн 91,7 хувь нь шууд холбоотой байгаа/;

- Гэмт хэрэгтэй тэмцэх үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоо муу, Цагдаагийн байгууллагын холбогдох албаны хүн хүч, техник, тээврийн хэрэгслийн хангалтгүй байдал, гарч байгаа хулгайн гэмт хэрэг улам нарийн зохион байгуулалттай болж байгаа байдал;
- Хулгайн гэмт хэрэгт холбогдсон хүмүүсийн дийлэнх нь ажилгүйчүүд байгаагийн дээр энэ төрлийн хэрэгт 14-өөс доош насны хүүхдийг шийтгэдэггүй зэрэг байдал /жил тутам дунджаар 400 гаруй насанд хүрээгүй хүн хулгайн хэрэг үйлддэг бөгөөд тэдний 80 орчим хувь нь хулгайг амжиргааныхаа эх сурвалж болгож байна/;

2016 онд Улсын хэмжээнд 12883 хулгайн гэмт хэрэг гарсныг 2006 онтой харьцуулахад хулгайн гэмт хэрэг 5,5 дахин өсчээ. Дүүргийн хэмжээнд 2016 оны байдлаар 908 хулгайлах гэмт хэрэг бүртгэгдэж, нийт 195.265.000 төгрөгийн хохирлыг иргэн, аж ахуйн нэгж байгууллагад учруулсан байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 25,8 хувиар өссөн байна.

Иймд энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, иргэд, аж ахуйн нэгж байгууллагын харуул, хамгаалалт, сонор сэрэмжийг дээшлүүлэх ажлыг дүүргийн хэмжээнд өрнүүлэх, бодлогын зохицуулалт хийх шаардлага гарч байгаа юм.

## **2.1. Зорилт**

Хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, иргэдийн болон байгууллагын өмчийг хулгайн гэмт халдлагаас хамгаалах, амгалан тайван ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэн, дүүргийн хэмжээнд хулгайн гэмт хэргийг саармагжуулж, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ.

## **2.2. Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

1/ Хулгайлах гэмт хэргийг бууруулах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд Төрийн болон Төрийн бус байгууллага, иргэд олон нийтийн оролцоо, хамтын ажиллагаа, үүрэг хариуцлагыг дээшлүүлэх;

2/ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд зохиогдож байгаа хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг дээшлүүлж, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах дүүргийн дэд зөвлөлийг байгуулан ажиллуулах;

3/ Нутаг дэвсгэртээ хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр байгууллага, аж ахуйн нэгжийн дотоод зохион байгуулалт, харуул хамгаалалт, дэг журмыг чангатгах, хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга замыг иргэдэд сурталчилах, нээлттэй мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх, шинээр үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан аж ахуйн нэгжүүдэд камержуулах талаар чиглэл өгөх, айл өрхийн сонор сэрэмжийг дээшлүүлэх чиглэлийн уриалга, зөвлөмж гарган, сурталчилж, хэрэг зөрчилгүй хороо, дүүрэг болгох хөдөлгөөн, аян өрнүүлэх;

4/ Хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх “Хөршийн холбоо”-г хороо бүрт байгуулан ажиллуулах;

### **2.3. Хүрэх үр дүн**

Хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд иргэд, аж ахуйн нэгж байгууллагыг татан оролцуулснаар хулгайн гэмт хэргийн гаралтыг сааруулан, нийт гэмт хэрэгт хулгайн гэмт хэргийн эзлэх хувийг бууруулан, илрүүлэлт нь өнөөгийн түвшингээс дээшилж, айл өрх, аж ахуйн нэгж, байгууллага өмч хөрөнгийн хамгаалалтаа сайжруулан хулгайд өртөхгүй байх нөхцөл бүрдэнэ.

### **3. Хөтөлбөр хэрэгжүүлэх шаардлага**

Гэмт хэрэг үйлдэх гол асуудлууд нь ядуурал, ажилгүйдэл, архидалт зэргээс болж үүсч байгаа нь судалгаанаас харагдаж байгаа юм. Монгол Улсын нэг иргэнд жилд дунджаар 19 литр архи, 32 литр шар айраг ноогдож байгааг Улаанбаатар хотын Цагдаагийн газраас мэдээлсэн бөгөөд өнгөрсөн онд хийгдсэн судалгаагаар Монгол Улсад 1925 литр спирт, 24774 литр архи, дарс, 64 сая литр шар айраг үйлдвэрлэсэн бол 36 сая литр архи импортолж, экспортод 154926 литр архи гаргасан байна. Түүнчлэн дотоодод үйлдвэрлэсэн болон импортлосон архины хэмжээг харьцуулж үзэхэд маш өндөр архины хэрэглээтэй гэсэн тоон үзүүлэлт гардаг бөгөөд энэ нь ДЭМБ-аас гаргасан зөвлөмжтэй харьцуулахад маш өндөр дүн гарч байгаа юм.

Өнөөдрийн байдлаар манай Улсад согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл бүхий спиртийн 7, архины 57, шар айрагны 19, дарсны 10 нийт 93 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулдаг гэсэн тоон судалгаа бий. Статистик дүнгээс үзэхэд манай улсад гарсан нийт гэмт хэргийн 1/3% нь хүнд, 1/2% нь онц хүнд хэрэг, Нийслэлд гарсан гэмт хэргийн 57,7 хувийг согтуугаар үйлдсэн байдаг. Чингэлтэй дүүргийн хэмжээнд 2016 оны байдлаар 708 хүнсний дэлгүүр үйл ажиллагаа явуулж байгаагаас 414 хүнсний дэлгүүр буюу 58,4 хувь нь согтууруулах ундаа худалдаалдаг хүнсний дэлгүүр байна.

2016 онд Нийслэлийн хэмжээнд согтуугаар гэмт хэрэг үйлдэгчид 10850 байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 2,9 хувиар өссөн бол Чингэлтэй дүүргийн хувьд согтуугаар гэмт хэрэг үйлдэгчид 2584 байгаа бөгөөд Нийслэлийн дүнтэй харьцуулахад 21,8 хувийг эзэлсэн байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 1,5 хувиар өссөн байна. Үүнээс харахад гэмт хэрэг гарах үндсэн шалтгаан нөхцөл нь архидан согтуурахтай шууд холбоотой байна. Иймд согтууруулах ундааны хэрэглээг багасгахад чиглэсэн арга хэмжээ авах шаардлагатай байгаа юм.

### **3. Зорилт**

Дүүргийн хүн амын согтууруулах ундааны хэрэглээг бууруулах, зохистой хэрэглээг төлөвшүүлэх, архидан согтуурснаас хvн амын эрvvл мэнд, нийгэмд учрах сөрөг үр дагаврыг багасгах, согтууруулах ундаа худалдан борлуулдаг,

түүгээр үйлчилдэг иргэн аж ахуй нэгж байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих, хүүхэд, өсвөр үеийнхнийг архидан согтуурахаас урьдчилан сэргийлнэ.

### **3.2. Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

1/ Архи, согтууруулах ундааны худалдаа, түүгээр үйлчилдэг иргэн, байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд тавих хяналт, шаардлагыг өндөржүүлэх, холбогдох хууль, дүрэм, журмыг зөрчсөн газруудын үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийг цуцлуулах, иргэдийн хяналт, мэдээллийн мөрөөр шуурхай арга хэмжээ авч ажиллах;

2/ Архидан согтуурснаас хүний эрүүл мэнд, гэр бүл, хамт олон, нийгмийн амьдралд учрах хор уршгийн талаар хүн амын мэдлэг, хандлагыг дээшлүүлэн архидалтгүй аж төрөх зан үйлийг хэвшүүлэх;

3/ Архины хэрэглээ, түүнээс үүдэн гарах хүн амын өвчлөл, нас баралт, хвчирхийлэл, осол гэмтлийн нийгмийн зардал буюу хор хөнөөлийн талаар өсвөр үеийнхэн, залуучуудад тайлбарлан таниулах, соён гэгээрүүлэх сургалт сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх;

4/ Архи хэтрүүлэн хэрэглэгч, архинд донтох өвчтэй иргэдийг архинаас татгалзах сэтгэл заслын сургалт, уулзалт, ярицлагад хамруулах, тэднийг хяналтад авч, архины хамааралгүй зөв иргэн болж төлөвшихөд нь дэмжлэг үзүүлэх арга хэмжээг боловсронгуй болгож, хүртээмжийг нь нэмэгдүүлэх;

### **3.3. Хүрэх үр дүн.**

Дүүргийн хүн амд архи, согтууруулах ундааны зохистой хэрэглээг төлөвшүүлэх, архидан согтуурснаас хvн амын эрvvл мэнд, нийгэмд учрах сөрөг үр дагаврыг багасгах, согтууруулах ундаа худалдан борлуулдаг, түүгээр үйлчилдэг иргэн аж ахуй нэгж байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналтыг чангатгаж, хүүхэд, өсвөр үеийнхнийг архидан согтуурахаас урьдчилан сэргийлнэ.

### **4. Хөтөлбөр хэрэгжүүлэх шаардлага**

Тээврийн хэрэгслийн тоо жил бүр тогтмол өсч, замын хөдөлгөөний нягтрал, ачаалал нэмэгдэхийн зэрэгцээ хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, ослын улмаас хүний амь нас, эрүүл мэнд, Төрийн болон Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн өмч хөрөнгөд хохирол учруулах явдал багасахгүй байна. Энэ нь замын хөдөлгөөнд оролцогчдоос Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Замын хөдөлгөөний дүрмийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж хэвшүүлэх хөдөлгөөний соёл ихээхэн дутагдаж байна.

Мөн Улс, орон нутгийн чанартай замуудад үүссэн эвдрэл гэмтэл нь замын хөдөлгөөний аюулгүй байдал болон тээврийн хэрэгслийн техникийн байдалд

нөлөөлдгөөс гадна замд үүссэн халтиргаа гулгааг цаг тухайд нь цэвэрлээгүйгээс явган зорчигч гэмтэх, тээврийн хэрэгслийн осол цөөнгүй гарч байна.

2016 оны байдлаар Нийслэлийн хэмжээнд зам тээврийн ослын нийт 25742 дуудлага мэдээлэл хүлээн авч шийдвэрлэсэн нь урьд оны мөн үетэй харьцуулахад 11,8 хувиар өссөн бөгөөд Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт 8252 дуудлага мэдээлэл хүлээн авч шийдвэрлэсэн нь Нийслэлийн хэмжээнд бүртгэгдсэн хэрэг, зөрчлийн 32,5 хувийг эзэлж байна. Нийт бүртгэгдсэн гомдол мэдээллийн 4201 буюу 50,9 хувь нь эд материалын хохиролтой зам тээврийн осол байна.

Иймд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах, хөдөлгөөнд оролцогчдын сахилга, соёлыг дээшлүүлэх, хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бодлого, үйл ажиллагааг дүүргийн хэмжээнд хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага тулгарч байна.

#### **4.1. Зорилт**

Замын хөдөлгөөний саатал, замын хөдөлгөөнд оролцогчдын дүрмийн бус үйл ажиллагааг багасгах, хөдөлгөөний соёл, сахилга хариуцлагыг дээшлүүлэхэд Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн үүрэг оролцоог тодорхойлж, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлнэ.

#### **4.2. Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

1/ Хөдөлгөөнд оролцогчдын сахилга, соёлыг дээшлүүлэх чиглэлийн сургалт, мэдээлэл, уриалга, зөвлөмж гарган, хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн улмаас үүсэх хор хөнөөл, замын хөдөлгөөний соёлыг хүүхэд, багачуудад төлөвшүүлэх, энэ талаарх мэдээллийг хөдөлгөөнд оролцогчдод ухуулан таниулах, соён гэгээрүүлэх сургалт, сурталчилгаа, өдөрлөг, аян, хөдөлгөөн өрнүүлэх;

2/ Сургууль, цэцэрлэгийн ойр орчимд хурд сааруулагч, тэмдэг, тэмдэглэгээг байршуулах, эцэг, эх, асран хамгаалагч, сургуулийн захиргаатай хамтран хүүхэд, багачуудыг зам тээврийн осолд өртөхөөс урьдчилан сэргийлэх, тэдний аюулгүй байдлыг хангуулах ажлуудыг өрнүүлэх;

3/ Замын аюулгүй байдлыг хангасан орчин бүрдүүлэх зорилгоор Төрийн болон Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн хамтын ажиллагааг өрнүүлэх;

#### **4.3. Хүрэх үр дүн.**

Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, ослын улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд учирч байгаа хохирлын хэмжээ буурч, иргэдийн замын хөдөлгөөний соёл дээшилсэнээр зам тээврийн хэрэг, осол, зөрчил буурна.



## **5. Хөтөлбөр хэрэгжүүлэх шаардлага**

Үндэсний статистикийн хорооны мэдээлэлд 2016 оны эхний хагас жилд гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн 764 гэмт хэрэг бүртгэгджээ. Энэ нь өмнөх оны мөн үеийнхээс 178 хэрэг буюу 30.4 хувиар өссөн үзүүлэлт юм. Түүнчлэн эхний хагас жилийн байдлаар хүчирхийллийн улмаас 7 хүн амь насаа алдсан байна. Сүүлийн 6 жилийн хугацаанд 90 гаруй хүн гэр бүлийн хүчирхийллийн улмаас амь насаа алдсан гэх албан ёсны тоо баримт байна. Цагдаагийн ерөнхий газрын статистик тоон мэдээнээс үзвэл, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг өмнөх оноос 30,4% -иар нэмэгдсэн бөгөөд гэмт хэргийн улмаас хохирсон 14.7 мянган иргэн хохирогч болсоны 4.7 хувь нь хүүхэд, 41 хувь нь эмэгтэйчүүд байна. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогч цагдаад хандах нь ховор, мөн энэ асуудал манай нийгэмд далд, нуугдмал байдгаас үзэхэд “чимээгүй хохирогчид” буюу хүчирхийлэлд өртөгсдийн тоо үүнээс ч илүү байх магадлалтай байна. Гэвч иргэд цагдаа, хуулийн байгууллагын хамгаалалтыг авч чадахгүй, амь насаа алдсан хохирогчдын тоо нэмэгдсээр байна. Гэр бүлийн хүрээнд ойр дотныхоо хүний амь насыг хөнөөх, гэр бүлээр нь хүйс тэмтрэх, хүүхдийг зовоон тарчлаах зэрэг хүнд ноцтой гэмт хэргүүд онц хэрцгий аргаар үйлдэгдэх болсон байна.

Чингэлтэй дүүргийн хувьд 2016 оны мэдээгээр эрсдэлт бүлгийн 304 хүүхэд байгаагаас хүүхэд хамгааллын үйлчилгээнд 940 хүүхэд, гэр бүл хамгааллын үйлчилгээнд 1025 эцэг эх, 25 хүүхэд (давхардсан тоогоор) хамрагдсан. Мөн 2016 онд 936 гэр бүл бүртгэгдэж, 325 гэр бүл цуцлалт хийгдсэнээс гадна Улсын хэмжээнд гэр бүлийн хүчирхийллээс үүдэлтэй гэмт хэрэг 1331 бүртгэгдэж өмнөх оныхоос 8,3 хувиар өссөн байна. Дүүргийн хэмжээнд 2016 онд гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн 410 гэмт хэрэг бүртгэгдсэн бөгөөд 510 иргэн энэ төрлийн гэмт хэргийн золиос болсон байна.

Иймд гэр бүлийн хүчирхийллийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хүчирхийлэлд өртөгсөд, гэрч хохирогчдыг хамгаалах, тэдэнд үзүүлэх нийгмийн үйлчилгээний арга хэлбэрийг боловсронгуй болгох, үр өгөөжийг нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлэх шаардлагатай байгаа юм.

### **5.1. Зорилт**

Гэр бүлийн гишүүдийг хүчирхийллээс ангид амар амгалан, аюулгүй амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, гэр бүлийн харилцаанд хүчирхийллийн бус арга, хэлбэрийг нэвтрүүлэх замаар хүний эрх, эрх чөлөөг хангах, гэр бүлийн хүчирхийллийн шалтгаан нөхцөл болон нийгмийн сөрөг үзэгдлийг арилгана.

### **5.2. Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

1/ Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгсдийн зан үйлд нөлөөлөх нийгмийн ажил, үйлчилгээг эрчимжүүлэх;

2/ Гэр бүлийн хүчирхийлэлд өртөгсөд, гэрч, хохирогч хүүхдийг хамгаалах өрөө, танхимыг байгуулан тохижуулах;

3/ Хүчирхийллээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажилд Төрийн бус олон нийтийн байгууллага, иргэд, хэвлэл мэдээллийн байгууллагыг татан оролцуулах тэдний оролцоо, дэмжлэгийг нэмэгдүүлэх ажлуудыг зохион байгуулах;

4/ Хүчирхийллийн эсрэг дэлхийн болон үндэсний хэмжээний тэмдэглэлт өдрүүдийн ач холбогдолыг иргэд, олон нийтэд тайлбарлан таниулах өдөрлөг, аян, хөдөлгөөн өрнүүлэх, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх мэдлэг олгох, дадал хэвшүүлэх сургалт, арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулах;

### **5.3. Хүрэх үр дүн.**

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажилд Төрийн болон иргэний нийгмийн байгууллага, иргэдийн оролцоо нэмэгдэж, гэр бүлийн хүчирхийллийг үл тэвчих нийгмийн ухамсар дээшилнэ.

## **6. Хөтөлбөр хэрэгжүүлэх шаардлага**

Гэрэлтүүлэгтэй байна гэдэг нь тухайн хотын гоёл чимэглэлээс гадна амар тайван амьдрах нэг баталгаа болдог. Харанхуй гудамжинд дээрэм, танхай, хүчингийн хэрэг байнга шахам гардагийг Цагдаагийн байгууллагаас сануулдаг бөгөөд Нийслэлийн хэмжээнд үйлдэгдсэн нийт гэмт хэргийн 15-25 хувь нь харанхуй гудамжинд үйлдэгддэг байна. Гэтэл Нийслэл хот өдрөөс өдөрт л хаяагаа тэлж, өдгөө 1 сая гаруй хүн амтай болж, хүн ам нэмэгдэхийн хэрээр хот алслагдсан гэр хорооллоор хүрээгээ тэлж байна.

Нийслэлийн хэмжээнд нийт 24 мянга орчим гэрэлтүүлэг байгаагаас 49% нь гэр хороололд, 38% нь нийтийн эзэмшлийн гудамж зам талбайд, 13% нь орон сууцны хороолол дунд суурилагдсан байна. Чингэлтэй дүүргийн хувьд 2012-2016 онд Улс, Нийслэл, дүүрэг орон нутгийн төсвийн хөрөнгөөр нийт 8811 гэрэлтүүлэг суурьлуулж, дүүргийнхээ 88 хувийг гэрэлтүүлэгтэй орчин болгосон байна.

Мөн дүүргийн нутаг дэвсгэрт үйлдэгдэж буй гэмт хэргийг бууруулах, урьдчилан сэргийлэх ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, орон сууц түүний гадна орчин, гэр хорооллын гудамж, талбайд нийт 522 байршлыг камержуулж, хяналттай орчин болгож чадсан юм.

Дээрх ажлуудын үр дүнд дүүргийн хэмжээнд гэмт хэргийн илрүүлэлтийн тоо өссөн үзүүлэлттэй байгаа нь судалгаанаас харагдаж байгаа юм. Тиймээс уг ажлыг цаашид бүрэн эрчимжүүлж, дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллага, иргэд, айл өрх, орон сууц, гудамж, нийтийн эзэмшлийн талбайг бүрэн камерын хяналттай цэг, гэрэлтүүлэгтэй орчин болгон гэмт хэрэг зөрчилгүй дүүрэг болгох зорилт дэвшүүлэн ажиллах шаардлага гарч байгаа юм.

## **6.2. Зорилт**

Дүүргийн хэмжээнд тавигдсан телекамеруудын хэвийн ажиллагааг хангаж, гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгддэг эмзэг цэгүүдийг камержуулах ажлыг үе шаттай зохион байгуулах, нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн гэрэлтүүлгийн ашиглалтын түвшинг сайжруулах, дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх, гэрэлтүүлгийн сүлжээг шинээр бий болгож иргэдийн эрүүл аюулгүй амьдрах нөхцөлийг бүрдүүлэн камерын хяналттай, гэрэлтүүлэгтэй орчин болгоно.

## **6.3. Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

1/ Гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгддэг гудамж талбай, олон нийтийн газар, эмзэг цэгүүдийг орон нутгийн төсвийн хөрөнгөөр камержуулах ажлыг үе шаттай зохион байгуулах;

2/ Орон сууцны орц, гэр хорооллын гудамж, нийтийн эзэмшлийн талбайг орон сууц өмчлөгчдийн холбоо, аж ахуйн нэгж байгууллагын идэвх, санаачилгад тулгуурлан тэдний хөрөнгөөр камержуулах ажлыг зохион байгуулах;

3/ Гудамж зам талбайн гэрэлтүүлгийн хамрах хүрээ, тоо хэмжээг нэмэгдүүлэхэд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татан оролцуулах, дэвшилтэт техник технологийг нэвтрүүлж үйл ажиллагааны зардлыг бууруулах;

4/ Эрчим хүчний зарцуулалт ихтэй, гэрэлтүүлэх чадвар муутай гэрэлтүүлэгийг эрчим хүчний хэмнэлттэй, гэрэлтүүлэх чадвар сайтай, ашиглалтын хугацаа урттай, урсгал зардал багатай, байгаль орчинд ээлтэй, өндөр үр ашигтай дэвшилтэт техник технологи бүхий гэрэлтүүлгийн системээр солих бодлого хэрэгжүүлэх замаар ашиглалтын зардлыг бууруулах;

## **6.3. Хүрэх үр дүн.**

Дүүргийн нутаг дэвсгэрийг бүрэн гэрэлтүүлэгтэй, камерын хяналттай орчин болгож, иргэдийн амар тайван амьдрах нөхцөл бүрдэнэ.

## **7. Хөтөлбөр хэрэгжүүлэх шаардлага**

Гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаа дан ганц Цагдаагийн байгууллагын эсвэл бусад хуулийн байгууллагын үүрэг биш бөгөөд гэмт хэрэг бол нийгмийн үзэгдэл юм. Энэ үзэгдэлтэй тэмцэх, гаргуулахгүй байх чиглэлээр хууль, хүчний байгууллагаас гадна бусад Төрийн болон Төрийн бус байгууллага, иргэд хамтарч ажиллах зайлшгүй шаардлага өнөөгийн нөхцөл байдалд бий болж байна.

2016 онд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газраас санаачилан дүүргийн нутаг дэвсгэрт иргэдийн хяналтыг бий болгох хүрээнд гудамж, байр бүрт Нийтийн эргүүл, Хэв журмын урамшилт

эргүүл, жижүүрийг томилон ажиллуулсан бөгөөд энэ ажилд дүүргийн нийт 900 гаруй иргэд идэвхтэй хамрагдсан байна. Иргэдийн эргүүл, жижүүр ажиллаж эхэлсэн хугацаанд дүүргийн хэмжээнд гэмт хэргийн гаралт 5,7 хувиар буурч, үүнийг дагаад илрүүлэлт 2.2 хувиар өссөн үзүүлэлттэй байгаа юм.

Иймд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг иргэдийн оролцоотойгоор зохион байгуулах, тэдний дэмжлэг туслалцаанд тулгаарласан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, хамтын ажиллагаанд суурилсан бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх явдал нэн чухлаар тавигдаж байна.

### **7.1. Зорилт**

Дүүргийн иргэд өөрсдийн оршин суугаа нутаг дэвсгэрийн аюулгүй амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх, гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор сайн дурын үндсэн дээр нэгдэж, энэ чиглэлээр нутгийн захиргааны байгууллага болон цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах тогтолцоог бүрдүүлнэ.

### **7.2. Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

1/ Иргэдээс гэмт хэрэг зөрчлийн талаарх мэдээ, дуудлага, санал гомдол хүлээн авч, холбогдох байгууллагад шуурхай хүргэх, шийдвэрлэх үйл ажиллагааг уялдуулах нөхцөлийг бүрдүүлэх;

2/ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийг татан оролцуулах, иргэдийн сайн дурын үйл ажиллагааг дэмжин урамшууллын байнгын тогтолцоог бүрдүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр гаргасан иргэд, олон нийтийн бүтээлч санаачлагыг дэмжин, ажил хэрэг болгох, энэ чиглэлээр бүлэг, зохион байгуулалтанд орох, хяналт тавих бүхий л хэлбэрийг дэмжин, хамтран ажиллах;

3/ Дүүргийн хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах салбар зөвлөл, Хороодын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон хамтарсан баг, Гудамж, байрны нийтийн эргүүл, Хэв журмын урамшилт эргүүлийн ажлын уялдаа холбоог нэгдсэн бодлогоор зохицуулах, хууль эрхийн болон цаг үеийн мэдээ мэдээллээр хангах, тэднийг чадваржуулах сургалт, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх;

4/ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд хууль сахиулах байгууллага болон иргэд, Төрийн бус байгууллага хоорондын уялдаа холбоог сайжруулах, шаардлагатай мэдээллийг харилцан солилцох, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хамтарсан тандалт, судалгаа хийх зэргээр хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;

### **7.3. Хүрэх үр дүн.**

Иргэд өөрсдийн оршин суугаа нутаг дэвсгэрийн аюулгүй амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах замаар гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, урьдчилан сэргийлэх иргэд-Төр захиргаа, хууль хяналтын байгууллагын хамтын ажиллагааны үр нөлөө дээшилнэ.

## **8. Хөтөлбөр хэрэгжүүлэх шаардлага**

Нийгэм, эдийн засгийн янз бүрийн нөхцөл байдлаас шалтгаалан гэмт хэргийн шинж чанар өөрчлөгдөж байгаатай холбогдуулан гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажилд техник технологийн шинэлэг арга хэрэгсэлүүдийг нэвтрүүлэх, дэлхийн жишигт нийцсэн техник, тоног төхөөрөмжийг ашиглах замаар гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга ажиллагааг боловсронгуй болгох явдал чухалаар тавигдаж байна.

Өнгөрсөн 2012-2016 оны хугацаанд хууль сахиулах байгууллагуудын материаллаг бааз, ажиллах орчин нөхцөл, техник хангамжийг сайжруулах хүрээнд Цагдаа, Прокурорын байгууллагад камерын хяналтын төв, уулзалтын өрөө, хурлын танхим, электрон дэлгэц зэрэг нийт 70 сая төгрөгийн өртөг бүхий тавилга, тоног төхөөрөмжөөр хангаснаар хууль хүчний байгууллагын үйл ажиллагаанд тодорхой хэмжээнд дэмжлэг болсон нь дүүргийн нутаг дэвсгэрт үйлдэгдэж буй ахуйн хүрээний гэмт хэргийн илрүүлэлтийн тоо өссөн үзүүлэлттэй гарсан тухай Цагдаагийн байгууллагын мэдээ, судалгаанаас харагдаж байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр дагавар, үр нөлөөг дээшлүүлэхэд Цагдаа, хууль сахиулах байгууллагуудын материаллаг баазыг бэхжүүлэх, техник технологийн шинэлэг арга хэрэгслийг тогтмол нэвтрүүлж, шинэчилж, хэрэглэснээр гэмт хэргийн илрүүлэлт өсч, урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөө дээшлэх сайн талтай юм.

### **8.1. Зорилт**

Гэмт хэргийн илрүүлэлтийг сайжруулахын тулд цагдаа, хууль хяналтын байгууллагуудын техник хангамж, ажиллах нөхцөлийг сайжруулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллаж байгаа ажилтнуудыг дадлагажуулж мэргэшүүлэх сургалт, семинар, зөвлөгөөнийг үе шаттайгаар орон нутгийн хэмжээнд зохион байгуулах, гадаад орнуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэж байгаа шинэлэг арга туршлагыг нэвтрүүлнэ.

### **8.2. Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

1/ Дүүргийн цагдаа, хууль хяналтын байгууллагын үйл ажиллагаанд орчин үеийн техник, технологийг нэвтрүүлэх замаар ажиллах орчин нөхцөлийг нь сайжруулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэх;

2/ Гэмт хэрэг мөрдөх ажиллагаанд мэдээллийн технологийг өргөнөөр нэвтрүүлэх, гэмт хэргийг түргэн шуурхай илрүүлэхүйц техник тоног төхөөрөмж, мэдээллийн технологийн идэвхтэй сүлжээг бий болгон, үр дүнтэй ашиглах;

3/ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хууль сахиулах байгууллагуудын боловсон хүчний чадавхыг дээшлүүлэх, гадаад Улс оронд туршлага судлуулах, мэргэшүүлэх, мэдлэг мэдээлэл олгох, сургалт, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх;

4/ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр гадаад орнуудын сайн туршлагыг нэвтрүүлэх, хамтын ажиллагааны хүрээнд харилцан туршлага солилцох ажлыг үе шаттайгаар зохион байгуулах;

### **8.3. Хүрэх үр дүн.**

Цагдаа, хууль хяналтын байгууллагуудын техник хангамж, ажиллах нөхцөл сайжирч, гадаад орнуудын сайн туршлагыг нэвтрүүлсэнээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх ажлын үр нөлөө дээшилнэ.

### **Дөрөв. Хөтөлбөрийн хууль, эрх зүйн зохицуулалт**

Монгол Улсын Үндсэн хууль, Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Авлигын эсрэг хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль бусад хууль тогтоомж, холбогдох дүрэм журам, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэл, дүүргийн нийгэм, эдийн засгийн зорилтыг баримтлан ажиллана.

#### **Тав. Хөтөлбөрийн зарчим.**

##### **5.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дараах зарчмыг баримтална:**

5.1.1. Хөтөлбөрийн агуулга, хэрэгжилт нь нийгмийн хөгжил, орон нутгийн онцлог, хэрэгцээ шаардлагад нийцсэн уян хатан байх;

5.1.2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх шинэлэг арга хэрэгсэл, техник технологи, дэвшилтэт арга туршлагыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх;

5.1.3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэн, гэр бүл, хамт олон, Төрийн болон Төрийн бус байгууллага, өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, олон нийт, иргэний нийгмийн байгууллагын оролцоог хангаж, салбар хоорондын хамтын ажиллагаанд тулгуурлах;

5.1.4. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа дүүргийн нийт хүн ам, эрсдэлт бүлэгт чиглэсэн, баримт нотолгоонд түшиглэсэн байх;

5.1.5. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг бүх төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоохтой холбоотой бусад хөтөлбөрийн үйл ажиллагаатай уялдуулах;

### **Зургаа. Хөтөлбөрийн хугацаа**

6.1. Хөтөлбөрийг 2017-2020 онд хэрэгжүүлнэ.

### **Долоо. Хөтөлбөрийн санхүүжилт**

7.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажилд шаардагдах хөрөнгийг дүүргийн жил бүрийн төсөвт тусган санхүүжүүлэхээс гадна дараах эх үүсвэрээс санхүүжүүлж болно.

7.1.1. Улсын төсөв

7.1.2. Орон нутгийн төсөв

7.1.3. Олон улсын төсөл, хөтөлбөр

7.1.4. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хандив

### **Найм. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалт**

8.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хяналт тавих үүргийг дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын болон дэргэдэх хэлтэс албад, дүүрэг дэх хууль сахиулах байгууллагууд хариуцан хэрэгжүүлнэ.

8.2. Иргэд, Төрийн бус олон нийтийн байгууллага, сайн дурын бүлгүүд нь хөтөлбөрийн зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд дүүргийн Төр, захиргаа, цагдаа, хууль сахиулах байгууллагатай хамтран ажиллана.

### **Ес. Хөтөлбөрийн хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт**

